



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01


Улаанбаатар хот

Албан хаагчдын цалин хөлсийг
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.4.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2014 оны Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай 332 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын албан хаагчдын 2017 оны албан тушаалын үндсэн цалин, нэмэгдлүүд, хоол, унааны хөнгөлөлтийг хавсралтаар баталсугай.
2. Албан хаагчдын цалин, нэмэгдэлүүд, хоол болон унааны хөнгөлөлтийг хавсралтын дагуу 2017 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн ажилласан хоногоор бодож олгохыг нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тушаал гарч мөрдөгдөх болсонтой холбогдуулан 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/15 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.ДЭЛГЭРЭХ